



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/453

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хан-Уул дүүрэгт байрлах журмын хашааны зүүн талын хэсэгт Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын Данснаас хасагдсан хөрөнгийг татан төвлөрүүлэх зорилгоор түр хугацаанд ашиглах бэлтгэл ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг зохих сангаас зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажлыг зохион байгуулж, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Д.РЭНЦЭНБЯМБА

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны .09... дугаар сарын .11...өдрийн А/БЗ дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	А.Мөнгөн	НӨАУГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Алтанцэцэг	НГЗБА-ны Хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Зөвшилцсөнөөр/
	Б.Батчимэг	ХУД-ийн ГЗБА-ны дарга /Зөвшилцсөнөөр/
	О.Төмөр	НӨАУГ-ын Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийн менежер
Нарийн бичгийн дарга:	Т.Оюунтуул	НӨАУГ-ын ЗСХ-ийн Тооцооны нягтлан бодогч